



АУДИТЫН КОД: САГ-2017/23/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн...	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Урьдчилж төлсөн тооцоог залруулах талаар	8
2.9.2	Бараа материалын үлдэгдлийг залруулах талаар	8
2.9.3	Дотоод хяналтын талаар	8
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	Дотоод хяналт	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн
2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 756

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГА Ж.БЯМБАДОРЖ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG5 Docx


070182

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн
2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 4/187 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага юм.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь дараахь ажлыг гүйцэтгэж байна.

- Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах
- Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах
- Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх
- Түүнчлэн Комиссын гишүүн Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцах, холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжлах

Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 5 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан

бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараахь асуудлыг дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн санхүүгийн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй үзлээ.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсөвт 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 731.6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 731.6 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

Хүний эрхийн Үндэсний комисс тайлант хугацаанд Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан дараах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл бичих
- Хууль тогтоомжийн дүн шинжилгээ, санал гаргах
- Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол шийдвэрлэх
- Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудлаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах асуудлаар зөвлөмж хүргүүлэх
- Хүний эрхийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах
- Хүний эрхийн асуудлаар олон нийтэд зориулсан ном товхимол, зурагт хуудас, хэвлэл мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа явуулах

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтот түвшин хөтөлбөр тус бүрээр бүрэн хангагдсан байна. Тухайлбал:

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн барьсан байна.

- Төвлөрсөн хорих анги, цагдан хорих байр, захиргааны журмаар албадан саатуулах, баривчлах байранд хяналт шалгалт зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 17 удаа хяналт шалгалт, судалгаа мониторинг 5 хийсэн байна.
- Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд 20 удаагийн саналыг боловсруулж хүргүүлжээ.
- Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх 500 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1784 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгсөн байна.
- Хүний эрхийн боловсрол дээшлүүлэх талаар 361 удаагийн 628.5 цагийн сургалтад 18733 хүнийг хамруулжээ.
- Хүний эрхийн асуудлаар олон нийтэд зориулсан нийт 13 төрлийн 22666 ширхэг ном товхимол, зурагт хуудас хэвлэж тараасан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
4. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (Тухай бүр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай дансанд хамаарах уламжлалт 5 дансанд 9, 4 дансанд хамаарах 5 хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж урьдчилан тооцоолсон бөгөөд батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

2.9.1 Урьдчилж төлсөн тооцоог залруулах талаар

Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.27 *"Урьдчилж төлсөн төлбөрийг үүссэн тооцоо буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж бүртгэнэ"* гэсэн заалтыг зөрчиж 22.9 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөр тооцоог зардалд тусгаж тайлант үеийн үр дүнг бууруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг 22.9 сая төгрөгөөр бууруулж, урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэх залруулах бичилт хийлгэв.

2.9.2 Бараа материалын үлдэгдлийг залруулах талаар

Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.20 *"Төсөвт байгууллага бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана."* гэсэн заалтыг зөрчиж зарцуулагдаагүй 19.5 сая төгрөгийн ном, товхимол тараах материалыг зардалд тусгаж, санхүүгийн байдлын тайланд бараа материалын үлдэгдлийг буруу илэрхийлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг 19.5 сая төгрөгөөр бууруулж, бараа материалын дансанд бүртгэх залруулах бичилт хийлгэв.

2.9.3 Дотоод хяналтын талаар

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн програмаар боловсруулаагүй, excel програм дээр боловсруулж байгаа нь бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, байгууллагын удирдлагыг санхүүгийн мэдээллээр цаг тухайд нь хурдан шуурхай хангах боломж дутмаг, санхүүгийн тайлангийн өгөгдөл архивлагдахгүйгээс өгөгдлийн сангүй болох зэрэг эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллоо эрсдэлээс урьдчилан сэргийлж цахимжуулах зөвлөмж өглөө.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал хандуулах бусад асуудал түүвэрлэн үзсэн горимын хувьд байхгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

2017 оны санхүүгийн тайланд хийх аудитаар үндсэн хөрөнгө болон бараа материалд бодитой оршин байгаа эсэхэд горим хэрэгжүүлэх зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 42.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг аудитын явцад залруулга хийлгэв. Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг хангаж байсан тул Төрийн аудитын тухай хуулийн 18.4-т заасны дагуу тус байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 879.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 17.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хүний эрхийн Үндэсний Комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Дотоод хяналт

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн програмаар боловсруулаагүй, excel програм дээр боловсруулж байгаа нь бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, байгууллагын удирдлагыг санхүүгийн мэдээллээр цаг тухайд нь хурдан шуурхай хангах боломж дутмаг, санхүүгийн тайлангийн өгөгдөл архивлагдахгүйгээс өгөгдлийн сангүй болох зэрэг эрсдэлтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллоо эрсдэлээс урьдчилан сэргийлж цахимжуулах арга хэмжээ авах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,864.4	63,216.9
АВЛАГА	1,750.3	18,538.0
УРЬДЧИЛГАА	-	22,880.5
БАРАА МАТЕРИАЛ	2,114.1	21,798.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	180,447.1	147,906.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	180,447.1	147,906.8
Биет хөрөнгө	171,807.1	142,506.8
Биет бус хөрөнгө	8,640.0	5,400.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	184,311.4	211,123.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,808.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,808.5
Өглөг	-	4,808.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	184,311.4	206,315.2
Засгийн газрын хувь оролцоо	184,311.4	206,315.2
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,347.9	108,347.9
Хуримтлагдсан үр дүн	67,063.3	89,067.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	184,311.4	211,123.7

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	968,499.0	901,709.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	968,499.0	901,709.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,000,829.5	879,705.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,829.5	879,705.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	938,027.0	863,088.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,213.7	515,546.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,496.7	56,524.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,620.0	42,840.0
Хангамж, бараа материалын зардал	60,544.4	54,420.0
Томилолт, зочны зардал	39,825.0	65,520.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,926.0	26,350.6
Бараа үйлчилгээний бусад зардал	172,401.2	101,886.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,802.4	16,617.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(I)-(П)	-32,330.5	22,003.7

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн
2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (Y1)=(Ш)+(1Y)-(Y)	-32,330.5	22,003.7
--	-----------	----------

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,650.5	0.0	196,650.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,650.5	0.0	196,650.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	19,991.5	0.0	19,991.5
Тайлант үеийн үр дүн	-32,330.5	0.0	-32,330.5
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,311.4	0.0	184,311.4
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	184,311.4	0.0	184,311.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,311.4	0.0	184,311.4
Тайлант үеийн үр дүн	22,003.7	0.0	22,003.7
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,315.2	0.0	206,315.2

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	976,880.3	903,360.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	976,880.3	903,360.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	976,875.3	903,305.8
УРСГАЛ ЗАРДАЛ	976,875.3	903,305.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,421.4	868,150.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,213.7	514,542.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,595.5	56,425.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,620.0	42,840.0
Хангамж, бараа материалын зардал	60,990.2	50,848.8
Томилолт, зочны зардал	39,825.0	65,520.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,926.0	26,350.6
Бараа үйлчилгээний бусад зардал	146,251.0	111,622.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,453.9	35,155.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(I)-(П)	5.0	55.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5.0	55.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5.0	55.0
Дотоод эх үүсвэрээр	5.0	55.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V1)=(IV)-(V)	-5.0	-55.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	731,634.8	731,621.5	13.3	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	731,634.8	731,621.5	13.3	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	715,030.8	715,017.5	13.3	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,542.6	514,542.6	-	100.0
Үндсэн цалин	473,655.6	486,901.0	-13,245.4	102.8
Унаа хоолны хөнгөлөлт	40,887.0	27,641.6	13,245.4	67.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,425.3	56,425.3	-	100.0
Тэтгэврийн даатгал	35,907.0	35,907.0		100.0
Тэтгэмжийн даатгал	4,103.7	4,103.7		100.0
ҮОМШӨ-ний даатгал	5,129.6	5,129.6		100.0
Ажилгүйдлийн даатгал	1,025.9	1,025.9		100.0
Эрүүл мэндийн даатгал	10,259.1	10,259.1		100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,840.0	42,840.0	-	100.0
Байрны түрээс	42,840.0	42,840.0	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	50,903.8	50,903.8	-	100.0
Бичиг хэрэг	12,922.6	4,716.6	8,206.0	36.5
Тээвэр, шатахуун	16,621.3	22,214.2	-5,592.9	133.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,359.9	21,994.4	-634.5	103.0
Ном, хэвлэл		1,558.8	-558.8	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	419.8	-419.8	
Томилолт, зочны зардал	12,475.2	12,475.2	-	100.0
Гадаад албан томилолт	-	12,127.2	-2,127.2	
Дотоод албан томилолт	12,475.2	348.0	12,127.2	2.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,363.9	26,350.6	13.3	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,578.9	23,578.9	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	200.0	186.7	13.3	93.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,585.0	2,585.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	11,480.0	11,480.0	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,480.0	11,480.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,604.0	16,604.0	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,604.0	16,604.0	-	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	16,604.0	16,604.0	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	731,634.8	731,621.5	13.3	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	731,634.8	731,621.5	13.3	100.0
Улсын төсвөөс санхүүжих	731,634.8	731,621.5	13.3	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.5	-0.5	

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн
2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.5	-0.5	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	99	99	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	49	49	-	100.0
Удирдах ажилтан	4	4	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	41	41	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49	49	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	45	45	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	-	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/ Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,074.5
УРСГАЛ ЗАРДАЛ	170,074.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,536.5
Томилолт, зочны зардал	53,045.5
Бараа үйлчилгээний бусад зардал	98,491.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,538.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,074.5
Нэмэлт санхүүжилтийн орлого	170,074.5
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	170,074.5